Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны
..... дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

"ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

2025.04.07-ны өдөр Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Биелэлт	Үнэлгээ
ЗҮРГАА.ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ				
Зорилт 6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.				
6.1.1	Цахим үндэстэн болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох "E-Mongolia"-д нэвтрүүлсэн төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээг 1000-д хүргэн нэмэгдүүлж, цахим гэрээ хэлцлийг байгуулах нөхцөл бүрдэж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдсэн байна.	“ХУР” нь төрийн үйлчилгээний мэдээллийг тасалдалгүй ажиллагаатай төвлөрсөн удирдлагатай платформоор дамжуулан байгууллага хоорондын уялдаа холбоог шинэ түвшинд гаргах, иргэд аж ахуй нэгжид хүрэх төрийн үйлчилгээг хөнгөвчлөх зорилготой мэдээлэл солилцооны систем юм. Бүх байгууллагууд улсын бүртгэлийн мэдээллийн санд байгаа дата мэдээллээ хур системээр дамжуулан авч байна. ХУР системд нийт 827 сервис ажилладаг бөгөөд төрийн 168 байгууллага хувийн 439 байгууллага хур системд холбогдон мэдээлэл солилцож байгаагаас Улсын бүртгэлийн байгууллага 444 сервисийг дангаараа нийлүүлэн суур мэдээллээр ханган ажиллаж байна. 2025.03.31-ны өдрийн байдлаар хур системээр нийт 4 тэрбум сервис дуудагдсанаас бүртгэлийн сервис 2,1 тэрбум удаа дуудагдсан үзүүлэлттэй байна. E-Mongolia портал системд Улсын бүртгэлийн 26-н төрлийн лавлагаа 52-н үйлчилгээ, E-Business портал системд Улсын бүртгэлийн 14-н төрлийн лавлагаа 58 төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд давхардсан тоогоор 44-н төрлийн лавлагаа, 110 төрлийн үйлчилгээг цахимжуулж нэвтрүүлсэн байна. Монгол улсын иргэдэд үнэ төлбөргүй олгох тоон гарын үсгийг улсын бүртгэлийн 116 киоск машин, бусад байгууллагын 1,477 ширхэг цахим /киоск/ машинаар тус тус олгодог болсон. Үүнд: - Гэрэгэ системс ХХК-489	100

			- Голомт банк АТМ-аар -330 - ХААН банкны АТМ-аар-442 - ТҮЦ-100 Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу 2022.05.01-ний өдрөөс 2025.03.31-ний өдрийн байдлаар Монгол Улсын 16 нас хүрсэн тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргасан 1,660,242 иргэнд тоон гарын үсэг олгосон. Үүнээс гар утсаар 770,834 иргэний үнэмлэхэд 889,408 *(Киоск машинаар 143,142)*	
6.1.3	Хаягийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх.	Улсын хэмжээнд хаягжуулалтын ажлыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, хэрэгжүүлсэн байна.	МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамжаар "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэ, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар УБЕГ-ын дарга ажиллаж байна. Уг ажлын хэсэг 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар хуралдаагүй байна. Хаягийн болон үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн санг байгуулах ажлыг эрчимжүүлэх, газрын кадастрын мэдээллийн системд өмчлөлийн газрын бүртгэл мэдээллийг түүхчилсэн байдлаар хөрвүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв бүртгэх хүрээнд бүртгэлийн байгууллагаас гарах өгөгдөл мэдээллийг авах замыг тодорхойлсон. 2024.02.07-нд ГЗБГЗЗЕГ-ын систем хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байгаа "Софт Мастер" ХХК-ийн ажилтанд УБЕГ-ын Үндэсний дата төвд байрлах мэдээллийн сангаас газар өмчлөлийн түүхчилсэн мэдээллийг улсын хэмжээнд харах сервисийн эрхийг өгсөн. УБЕГ-т 2025.02.05-ны өдөр ҮАГ-ын аудитор Баяртогтох, Мэдээллийн технологи хариуцсан аудитор Бүрэнхүү нар Улсын бүртгэлийн байгууллагын зүгээс газар, үл хөдлөх хөрөнгийн хаягийн дундын нэгдсэн мэдээллийн санг байгуулах зорилгоор хийж хэрэгжүүлсэн ажилтай танилцахаар ажиллав. Улсын бүртгэлийн байгууллагын дундын мэдээллийн сангийн сервисийн багана, өгөгдлийн талаарх тайлбар, мэдээллийг 2025.02.06-ны өдөр цахим	70

			шуудангаар хүргүүлсэн. Мөн ЭХЭУБГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хаягийн болон газар, хот байгуулалтын мэдээллийн сантай холбогдох, дундын мэдээллийн сантай болох, эрхийн улсын бүртгэлд шаардлагатай мэдээллийг авч хэрэглэх байдлаар тусгуулан хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.	
6.1.4	Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх.	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй 500 мянга гаруй барилгын зурган болон бүртгэлийн мэдээллийг засварлаж, өгөгдлийн санг байгуулан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын системтэй холбосон дундын мэдээллийн санг байгуулж, салбар хоорондын уялдааг хангасан байна.	Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас олгодог бүх гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн “блокчэйн” технологийг нэвтрүүлэхээр 2022 оноос хойш төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд ADB төслөөр эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрт олгох программ хангамжийн бодлогын даалгавар боловсруулан батлуулсан. 2025.04.01-ний өдрөөс программ хангамж хийгдэж эхлэхээр төлөвлөгдсөн. Блокчэйн технологийг ашиглан улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох дэд бүтцийг зохион байгуулах шийдлийг бэлтгэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай хамтран ажиллах төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлэн ажиллаж байна.	30
Дундаж үнэлгээ хувиар				**66.6**
Оноо				**3.3**

--oOo--